

Лого бүтээх уралдаанд өргөнөөр оролцохыг урьж байна!

Элчин сайдын яамдууд 2024 онд тохиох тэмдэглэлт ойг угтуулан уралдаан зарлаж байна

„Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жил“ тэмдэглэлт ой 2024 онд тохиож байна.

Тэмдэглэлт ойг тохиолдуулан Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайдын яам, Холбооны Гадаад хэргийн яамыг төлөөлөн ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам хамтран цуврал баяр ёслол болон хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж байна. Та бүхнийг 2024 онд тохиох онцгой үйл явдалд үнэтэй хувь нэмрээ оруулан тэмдэглэлт ойн жилийн логоны уралдаанд саналаа ирүүлэхийг урьж байна.

Ойн жилийн логоны санаанууд ойн арга хэмжээнүүдэд зориулан хийх зурагт хуудас, сурталчилгааны зүйлс, тайз, дэлгэцийн зураг болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээхэд ашиглагдах юм .

◆ Хугацаа

Бүтээл ирүүлэх хугацаа: 2023 оны 11 дүгээр сарын 9-11-ний хооронд
Шагналт байранд шалгарсан бүтээлийн оролцогчдыг 2023 оны 12 дугаар сарын эхээр цахим захидал /э-мэйлээр/ мэдэгдэнэ.

◆ Оролцогчид

Хувь хүн болон багаар оролцож болно. Ингэхдээ нэг буюу хэд хэдэн логоны загвар ирүүлэх боломжтой. Гагцхүү ХБНГУ болон Монгол Улсаас ирүүлсэн бүтээлүүдийг шалгаруулна.

◆ Хаана

Илгээх хаяг: info@ulan.diplo.de

Э-мэйлийн гарчигт бичих: Logo 50 эсхүл 50 жилийн ойн лого

Цахим хуудаснаас татан авсан анкетыг бүрэн гүйцэт бөглөж хавсаргана уу. Зөвхөн бүрэн гүйцэт бөглөсөн анкетыг ирүүлсэн тохиолдолд лого бүтээх уралдаанд оролцох боломжтой.

◆ Шагнал

Лого бүтээх уралдаанд ирүүлсэн шилдэг 3 бүтээлийг шалгаруулж, мөнгөн шагналаар шагнана.

1-р байр 3,000,000 төгрөг¹

2-р байр 2,000,000 төгрөг

3-р байр 1,000,000 төгрөг

¹ Германаас шалгарсан оролцогч тухайн мөнгөн дүнг 2023.11.23-ны ханшаар евро руу хөрвүүлсэн дүнгээр хүлээн авна.

Анкет

Оролцогч (хувь хүн эсхүл баг)	Овог, нэр	
	Иргэншил	*Энэ мэдээлэл нь шалгаруулалтад нөлөөлөхгүй бөгөөд зөвхөн статистикийн зорилгоор ашиглагдана.
	Э-мэйл	
	Утас	
Лого	Товч танилцуулга	[Танилцуулга]
		- Сонгон шалгаруулалтыг хялбарчлахын тулд эхлээд логог PDF, JPG файлаар цахимаар илгээнэ. - Шалгарсан тохиолдолд файлыг анхны хэлбэрээр нь өгөх ёстойг анхаарна уу.

Уралдаанд оролцох нөхцөл

§ 1

Логоны зохиогчийн буюу ашиглах эрх эзэмшигчийн овог, нэр

миний бие “Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жил”-ийн ойг тохиолдуулан Холбооны Гадаад хэргийн яам болон Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайдын яамнаас зохион байгуулж буй лого бүтээх уралдаанд хүргүүлсэн бүтээлийн зохиогчийн эрхийн буюу бүтээлийг ашиглах онцгой эрхийн эзэмшигч гэдгийг үүгээр нотолж байна. Хуулиар зөвшөөрөгдсөн дагалдах хэрэгсэл, хуулиар хамгаалагдсан иш татах эрх чөлөөнөөс гадна зохиогчийн эрхээр хамгаалагдсан бүтээлийн загварыг хэсэгчлэн болон өөрчилсөн байдлаар ашиглаагүй болно. Холбооны Гадаад хэргийн яамыг би үүгээр гуравдагч этгээдийн нэхэмжлэлээс чөлөөлж байна.

§ 2

Холбооны Гадаад хэргийн яам болон Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайдын яаманд илгээсэн миний бүтээлийг ашиглах, хэрэглэх (засварлах, хуулбарлах, түгээх гэх мэт) онцгой эрхийг олгож байна. Тус бүтээлийг өөрөө ашиглах эрхээсээ би үүгээр татгалзаж байна.

Ашиглах эрх олгох нь цаг хугацаа, байршил, агуулгын хувьд аливаа хязгаарлалт байхгүй бөгөөд ашиглах эрхийг гуравдагч этгээдэд олгохыг би үүгээр зөвшөөрч байна. Уралдаанд

хүргүүлсэн миний бүтээлийг заавал ашиглах нэхэмжлэл гаргах боломжгүйг би зөвшөөрч байна.

Уралдаанд шалгарсан тохиолдолд миний бүтээлийг албан ёсны лого болгон ашиглахдаа өөрчлөлт оруулахыг Холбооны Гадаад хэргийн яам болон Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайдын яаманд би зөвшөөрч байна.

§ 3

Хоёрдугаар зүйлд заасны дагуу олгосон эрхийн төлөө нөхөн төлбөр олгохгүй.

Лого бүтээх уралдаанд оролцох болон бүтээлийг түгээх болон ашиглах эрхийг олгох нь Германы хуулийн дагуу явагдана. Хууль, эрх зүйн хүрээнд нэхэмжлэл гаргах боломжгүй болно.

Он, сар, өдөр

Оролцогчийн/оролцогч насанд хүрээгүй бол
асран хамгаалагчийн гарын үсэг